



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 8/119

Батноров сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дугаар заалт, "Ургамал хамгааллын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1. Хөнөөлт мэрэгч тархсан Эхэнбүрд 2 дугаар багийн Эргэцэг, Зүүн булаг, Баруун булаг, Идэрмэг 5 дугаар багийн Дэлгэр-Овоо, Тунсаг, Малгар, Бат-Өлзийт, Шанага нэртэй 6 мянган га бэлчээрт микробиологийн аргаар, мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 2024 оны 10 дугаар сарын 01- ний өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг сумын хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Ч. Чинхүсэл (Хөдөө аж ахуйн тасгийн
мэргэжилтэн)

Нарийн бичгийн даргаар
Гишүүдэд

Э.Зулцэцэг (Газрын даамал)
Б.Өсөхбаяр (БОХУБайцаагч)
Ж.Ариунбаяр (Байгаль хамгаалагч)
Б.Өсөхбаяр (Баян багийн Засаг дарга)

3. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх арга хэмжээний бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж 10 дугаар сарын 25-нд үр дүнг илтгэхийг ажлын хэсгийн ахлагч Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ч.Чинхүсэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЖАВХЛАНБАЯР

233424221